

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№22/561

ШУС, НУС

2021

**МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙД МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН  
ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР**

Б.Наранбаатар\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

**Түлхүүр үгс:** мэдээллийн агентлаг, ОНМХ-ийн систем, МОНЦАМЭ, гадаад сурталчилгаа, баримт нягтлах, сэтгүүл зүй, мэргэжлийн ёс зүй, хариуцлага.

**М**онголын сэтгүүл зүйн салбарын анхлагчдын нэг, Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг нэгэн зуун жилийн түүхийн хуудсаа эргүүлэн эвхэж, энэ онд өнгөрснөө цэгнэн, ирээдүйгээ төлөвлөж байна. МОНЦАМЭ агентлаг нь манай орны уншигчид, хэвлэл мэдээллийн салбарынхны хувьд бүтээсэн үйл хэрэг, үлдээсэн сан хөмрөг, хуримтлуулсан туршлага, боловсруулсан зарчим, чиг шугамаараа үнэт өвийг нэгэнт бий болгожээ.

108 жилийн түүхтэй үндэсний сэтгүүл зүйн салбарт бүхэл зууны турш манлайлан тэргүүлэгчийн үүрэг гүйцэтгэж ирсэн нь МОНЦАМЭ-гийн гавьяа бөгөөд байр суурь билээ. Ингээд түүхэн он цагийн товчоо, тэмдэглэлт олон үйл явдлыг тоочихыг хойш тавьж, өгөгдсөн сэдвийн хүрээнд тус агентлагийн Монголын сэтгүүл зүйн хөгжил дэх

хувь нэмрийг есөн зүйл баримтаар сийрүүлэн тоймлосноо сонирхуулъя.

Монголын ОНМХ-ийн систем, тогтолцоог бүтэн байлгах томоохон үүрэг энэ агентлагт ногддог. Аливаа улс орны мэдээллийн хэрэгслийн тогтолцоог авч үзэж, судлан дүгнэхдээ бүрэлдэхүүн хэсгүүдийн бүрэн эсэхэд өндөр ач холбогдол өгдөг билээ. Сонин, сэтгүүл, радио, телевиз, баримтат кино, цахим хэвлэл, мэдээллийн агентлаг гэсэн долоон бүрэлдэхүүн хэсэгтэйгээр энэхүү тогтолцоог судалдаг, үнэлдэг. Тэгвэл 1921 онд анх үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн МОНЦАМЭ нь манай орны цор ганц мэдээллийн агентлаг байж ирлээ. Хэдийгээр Монголд “мэдээллийн агентлаг” гэсэн нэр томъёог “дураар” хэрэглэн чамирхдаг байгууллага хэд хэд бий боловч сэтгүүл зүйн онол, практикт тодорхойлсон үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлж, статусаа баталгаажуулан тодотгосон нь МОНЦАМЭ цор ганцаар билээ. Иймд МОНЦАМЭ агентлаг нь улс төрийн нөхцөл байдал, шилжилт, өөрчлөлтөөс үл хамааран Монголын ОНМХ-ийн системийг бүрэн бүтэн байлгадаг,

тулгын чулууны нэг хэмээн дүгнэж болохоор байна. 2021 оны байдлаар Монгол Улсад 513 хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажиллаж байна (МХХ, 2021). Нийт хэвлэл мэдээллийн тал шахам хувь нь орон нутагт төвлөрдөг манай ОНМХ-ийн системийн хувьд МОНЦАМЭ-гийн үүрэг оролцоо их бөгөөд орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ нь Монголдоо хамгийн том, тогтвортой нь юм.

Гадаад сурталчилгааны ганц дайчин. Аливаа улс орон түүхэн цаг хугацааны мөчлөгт өөрийн гэсэн гадаад бодлоготой, тэрхүү бодлогоо хэрэгжүүлэх “зөөлөн” стратеги, зориудын хэрэгслүүдтэй байдаг. Тэдгээрээр дамжуулан гадаад мэдээллийн бодлого, гадаад сурталчилгаа явуулж, Төрийн нэгдмэл бодлогоо дэмжих үүрэг гүйцэтгэдэг. Хэн нэгэн хүчирхэг улсын хувьд энэхүү гадаад бодлогыг мэдээллээр дэмжих ажил нь бүхэл бүтэн цогц тогтолцоо, олон төрөлт мэдээллийн хэрэгслүүд, олон улсын түвшний сүлжээ телевиз, агентлагуудын нэгдмэл үйл ажиллагаагаар хангагддаг бол манай орны хувьд МОНЦАМЭ агентлаг энэ эрхэм үүргийг 100 жил нуруундаа үүрч ирлээ. Орчин үеийн дипломат харилцааны чухал эд эс мэдээлэл сурталчилгааны гадагш урсгал Ардчилсан Монгол Улсын хувьд ч дан ганц МОНЦАМЭ агентлагийн үйл ажиллагаа, идэвх санаачилгаар урагшилж буй нь нэг талаас бахдам, нөгөө талаас бодууштай, анхаарууштай баримт юм.

Монголын албан ёсны байр суурийг зарлагч эх сурвалж. Монгол

Улстай дипломат харилцаа бүхий улс орнууд, тэдгээрийн төлөөлөл субъектүүд, Монголыг төлөөлөн гадаад улс оронд суугаа дипломат албаныхан, хэвлэлийн атташе нар, тэдгээртэй хамтран ажилладаг хэвлэлийнхний хувьд манай улсад болж буй сэдэв, үйл явдлын талаарх албан эх сурвалж нь МОНЦАМЭ байсаар ирсэн, одоо ч тийм. Өөрөөр хэлбэл, “Дэлхийг Монголд - Монголыг дэлхийд” гэсэн уриа үгэндээ багтаж, Монголын тухай мэдээллийн номер нэг эх сурвалж хэвээр байна. Мэдээллийн урсгал, орон зай, платформууд өргөжин тэлэх тусам “мэдээллийн найдвартай эх сурвалж” гэх томъёолол нь сэтгүүл зүйн салбарт өргөмжлөл-тодорхойлолт болж буй өнөө үед чухам энэ чиглэлийн үйл хэрэг нь манай сэтгүүл зүйн хөгжилд оруулж буй томоохон хувь нэмэр болно.

**Ш**илдэг сэтгүүлчдийн “гал тогоо”. Өнгөрсөн зуун жилийн хугацаанд МОНЦАМЭ агентлагт Монголын сэтгүүл зүйн сор болсон эрхмүүд ажиллаж, бүтээл туурвилаа үлдээж, залгамж халаагаа бэлдэж ирсэн уламжлалтай. Монголын сэтгүүл зүйн өөр ямар ч байгууллагаас төрсөн салбарын алдартан, гавьяатнуудын тоо МОНЦАМЭ агентлагийг гүйцэхгүй биз ээ.

Төр нийгмийн нэрт зүтгэлтэн С.Жалан-Аажав, Төрийн шагналт, яруу найрагч Ч.Чимэд, МУСГЗ Х.Цэвлээ, Б.Пүрэвдаш, МУСГЗ, доктор, профессор Т.Баасансүрэн, Ерөнхий сайд асан С.Баяр, зохилч орчуулагч, МУСГЗ Го Аким, дипло-

матч, доктор Д.Баярхүү гээд энэ хамт олноос төрөн гарсан алдартнууд, тэдний үйл хэрэг тод мөртэй билээ (Т.Баасансүрэн, 2011). Энэ нь тус агентлаг манай сэтгүүл зүйн нэр хүндтэй, манлайлагч байгууллага байгаад зогсохгүй шилдэг сэтгүүлч, нийтлэлчид төрөн гардаг “гал тогоо” /школа/ мөн болохыг батална.

**М**эргэжлийн ёс зүй, хариуцлагын үлгэр жишээ байсаар ирэв. Сэтгүүл зүйн мэдээллийн анхдагч зарчим, “А” үсэг нь үнэн бодит байдал билээ. Гэвч болсон үйл явдал, сэдвийг боловсруулан бэлтгэж өргөн олонд түгээхэд үнэн бодит байдлыг хангана гэдэг тийм амар хялбар зүйл биш гэдэг нь илэрдэг. Чухам энэ анхдагч зарчмыг биелүүлэхэд сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн алдаа түгээмэл гарч, хэвлэл мэдээллийн хариуцлагын асуудал босож ирдэг юм. МОНЦАМЭ агентлагийн хамт олон Монголын сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбарт мэргэжлийн ёс зүй, хариуцлагын үлгэр дуурайлал, жишиг болж ирснийг онцлох нь зүйтэй болов уу. 2000 оны 9-р сард батлагдаж байсан МОНЦАМЭ-гийн “Алтан дүрэм” (Д.Отгонбаяр, 2011) олон хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд дотоод журам, ёс зүйн код боловсруулах эш үндэс болсныг хэлэх нь зүйтэй.

Баримт нягтлах найдвартай эх сурвалж. Олон нийтийн мэдээлэл харилцаа, түүний боломжит платформууд хөгжиж, зориудын мэдээллийн хэрэгслүүдээс үл хамаарсан баримт, мэдээлэл иргэдэд ихээр хүрч, тэд өөрсдөө ч энэ орон зайн

идэвхтэй тоглогч болсон өнөө үед мэргэжлийн сэтгүүл зүйд баримтыг нягтлах нь нэн чухал зүйл болсон билээ. Баримт нягтлах онлайн системүүдийг хөгжүүлж, хиймэл оюун ухаан, эрх зүйн зохицуулалтын механизмаар “хуурамч” мэдээг хязгаарлах боломжийг өнөөгийн сэтгүүл зүй эрэлхийлж байна. Мэргэжлийн сэтгүүл зүй энэ их мэдээллийн урсгал, нийлүүлэлтээс ялгарч, үзэгч, уншигчийн итгэл үнэмшлийг хадгалах цор ганц арга нь баримт бүрийн үнэн бодит эсэхийг нягтлах явдал юм. Мэдээллийн эх сурвалжууд өөрийн субъектив байр суурь, үзэл бодол, өнцгийг илэрхийлэх нь элбэг тул уншигчийн найдвартай, итгэл хүлээсэн хэвлэл мэдээллийн байгууллага гэсэн статусыг хадгалах нь амаргүй даваа болжээ. МОНЦАМЭ-гийн хувьд зөвхөн уншигч хэрэглэгч төдийгүй, бусад олон мэдээллийн хэрэгслийн баримтаа нягталдаг эх сурвалж болсон, байсаар ирсэн нь үнэн.

Нэр томъёоны найдвартай лавлах. МОНЦАМЭ агентлаг орос, англи, хятад, япон хэлээр мөн монгол үндэсний бичгээр сонин эрхлэн гаргаж, мэдээллийн сайтаа идэвхтэй хөгжүүлж байна. Эдгээр сонин, сайт нь гадаад эх сурвалжуудтай хамтран ажилладаг хэвлэл мэдээлэл, бусад байгууллагуудын ажил үйлсэд үнэ цэнтэй тусыг хүргэдэг юм. Аливаа газар орон, байгууллагын нэр, монгол онцлогтой нэр томъёоны орчуулга, хэл найруулга, тогтсон хэллэгийн найдвартай лавлахын үүргийг эдгээр сонин гүйцэтгэж байна. Он удаан жил

гадаад хэлээр Монголын үйл явдал, онцлох мэдээллийг бусад улс орны агентлаг, дипломат албад, хэвлэлийнхэнд түгээхийн зэрэгцээ сэтгүүлч, редакцын хувьд нэр томъёоны орчуулгын гол лавлах байна гэдэг бол бага биш хувь нэмэр юм.

Гадаад хэл дээрх хэвлэлүүдийг онцлох нь. МОНЦАМЭ агентлаг The Mongol

messenger,

Новости Монголии, Монгору цушин, Мөнгу Шяоши бао сонин, Mongolia Today сэтгүүлийг эрхлэн гаргаж,

montsame.mn

сайтаа таван хэл, зургаан бичгээр хөтлөн Монголын мэдээллийн орон зайд нэн чухал байр сууриа хэдийн эзэлжээ. Улс орнууд ардчилал, эдийн засгийн интеграцид улам бүр нэвчиж, харилцан хамааралд оршиж тогтох болсон энэ

үед Монгол Улсын тухай мэдээлэл аль болох олон хэл дээр, аль болох олон эх сурвалжаар идэвхтэй, тогтмол түгж байж улс орны гадаад имиж, цаашлаад бизнес, аялал жуулчлал, энгийн иргэдийн харилцаанд эерэг нөлөөтэй юм. Хэдийгээр Монголын тухай мэдээллийг аль нэг гадаад хэлээр, эсвэл хэд хэдэн

хэлээр хүргэдэг эх сурвалжууд бий боловч МОНЦАМЭ-гийн хэвлэлүүд шиг тогтмол, иж бүрэн, хүртээмж өндөртэй нь үгүй билээ. Агентлагийн хувьд гадаад хэл дээрх хэвлэлүүдээ улам бүр хөгжүүлэх, мэдээллийн багтаамж, үр ашигтай хүртээмжид цаашид анхаарах нь зүй боловч өнөөгийн амжилт нь чамлах зүйл биш юм.

Үндэсний бичгээрээ хэвлэгддэг үнэт өв “Хүмүүн бичиг”. Монголын ард түмний бахархал, түүх, ёс уламжлал, цэц мэргэнийг шингээн тээгч үндэсний бичгээ сурталчлан таниулах, хэрэглээг нь тэлэх, заан үлгэрлэх хүндтэй ажлыг “Хүмүүн бичиг” сонины редакц нэр төртэй авч яваа билээ. Хэдийгээр монгол бичгээр мэдээллээ хөрвүүлэх замаар уншигчдад хүргэдэг мэдээллийн сайт, судалгаа эрдэм шинжилгээний бүтээ-

лүүд бий боловч, үүх түүх болон үлдэх өнөөдрийн он цагийн товчоог хураан хуримтлуулж байгаа нь “Хүмүүн бичиг” сонины онцлог юм. Энэ хэрээр үндэсний бичиг, эх хэлний үгийн сан, хэл найруулга, монгол хэлний хөгжилд орчин цагийн толь бичиг болон төлөвшсөн энэхүү хэвлэл МОНЦАМЭ-гийн



**Мэдээллийн агентлагийн уламжлалт үйл ажиллагааны зарчим, хэлбэр мөн өөрчлөгдөн, мэдээлэл харилцааны шинэ эрин үед менежмент, эрх зүйн орчин, хамтын ажиллагааны шинэ хэлбэр лүү шилжиж эхэллээ. МОНЦАМЭ агентлаг ч эдгээр сорилтуудтай тулгарч байгаа бөгөөд өнгөрсөн зуун жилийн хугацаанд манлайлан түүчээлсэн зам мөрөө үргэлжлүүлж, Монголын сэтгүүл зүйн хөгжилд чиг баримжаа болсон олон ажил, арга хэмжээ, шинэ санаачилга, шилдэг сэтгүүлчид энэ хамт олноос төрөн гарна гэдэгт итгэлтэй байна.**



Монголын сэтгүүл зүйд барьсан том бэлэг, том гавьяа юм.

Дэлхий нийтийн мэдээллийн зах зээл, мэргэжлийн сэтгүүл зүйн чиг хандлага хувьсаж байна. Уламжлалт мэдээллийн хэрэгслүүд олон сорилттой нүүр тулж, орчин цагийн хэрэглэгчийн мэдээллийн шаардлагад нийцэхийн зэрэгцээ тэднийг төлөвшүүлэн хөтлөх, мэргэжлийн үнэ цэнээ хадгалах шаардлага тулгарч байна. Мэдээллийн агентлагийн уламжлалт үйл ажиллагааны зарчим, хэлбэр мөн өөрчлөгдөн, мэдээлэл харилцааны шинэ эрин үед менежмент, эрх зүйн орчин, хамтын ажиллагааны шинэ хэлбэр лүү шилжиж эхэллээ. МОНЦАМЭ агентлаг ч эдгээр сорилтуудтай тулгарч байгаа бөгөөд өнгөрсөн зуун жилийн хугацаанд манлайлан түүчээлсэн зам мөрөө үргэлжлүүлж, Монголын сэтгүүл зүйн хөгжилд чиг баримжаа болсон олон ажил, арга хэмжээ, шинэ санаачилга, шилдэг сэтгүүлчид энэ хамт олноос төрөн гарна гэдэгт итгэлтэй байна.

**Т**өгсгөлийн оронд дүгнэн хэлэхэд МОНЦАМЭ агентлагийн өмнө тулгамдаж буй, ойрын ирээдүйд шийдвэрлэвэл зохистой, үр дүнтэй санаачилга үгүйлэгдэж байгаа нэгэн зүйлийг онцолъё. 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” хэмээн заасантай холбоотойгоор агентлагийн статус хараахан тодорхойгүй явж ирсэн. Ялангуяа, 2005 онд Үндэсний олон нийтийн радио, телевизийн тухай

хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр МОНЦАМЭ-гийн эрх зүйн тодорхойгүй байдал тодорч харагдах болов. Хэдийгээр төсвөөс санхүүжиж байгаа боловч Засгийн газар, төрийн субъектүүдээс хараат бус үйл ажиллагаа эрхэлж буй нь энэ хамт олны хичээл зүтгэлийг илтгэнэ. Гэвч хууль, эрх зүйн зайлшгүй зохицуулалт, шинэ менежмент шаардагдсаар буйг тэмдэглэх нь зүйтэй.

### Эшлэл

1. Монголын хэвлэл мэдээлэл Өнөөдөр. 2021. Мониторингийн судалгааны эмхэтгэл. Хэвлэлийн хүрээлэн. УБ. 4-р тал.
2. Баасансүрэн Т. 2011. МОНЦАМЭ: Үе үеийхэн. УБ. 205-р тал.
3. Отгонбаяр Д. 2011. Монголын хэвлэлийн түүхэнд МОНЦАМЭ-гийн эзлэх байр суурь// Монголын сэтгүүл зүйн үүсэл хөгжил. 2011. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 74-р тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2011. МОНЦАМЭ: Үе үеийхэн. УБ.
2. Монголын хэвлэл мэдээлэл Өнөөдөр. 2021. Мониторингийн судалгааны эмхэтгэл. Хэвлэлийн хүрээлэн. УБ.
3. Монголын сэтгүүл зүйн үүсэл хөгжил. 2011. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.
4. Норовсүрэн Л. 2006. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. 3-р боть. УБ.

### Summary

In this article entitled “The role and place of the MONTSAME news agency in the development of journalism in Mongolia,” the author draws attention to the 100th anniversary of MONTSAME

news agency, analyzes and evaluates its activities. The author especially emphasizes the fact that IA Monzame replenishes the media system in Mongolia as the first and only news agency in the country. The article also highlights the

facts that IA Monzame has become the standard of professionalism and ethics of the country's journalists, and plays an important role in non-political information policy, publishing newspapers in English, Russian, Chinese and Japanese.